



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/76/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:Bujinkhandj@audit.gov.mn">Bujinkhandj@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:Sanchirmaas@audit.gov.mn">Sanchirmaas@audit.gov.mn</a>
---	--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 51

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ  
ГАЗРЫН А ХЭСГИЙН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Ч.БАЯРБАТ ТАНАА

07020575

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	46,664,666.02	35,508,089.20
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	8,163,400.00	0
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	8,163,400.00	0
33510	Байгууллагаас авах авлага	8,163,400.00	0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	38,501,266.02	35,508,089.20
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	37,154,794.02	34,610,441.20
35410	Бичиг хэргийн материал	390,352.82	324,000.00
35420	Аж ахуйн материал	19,764,541.20	23,273,541.20
35440	Түлш, шатах тослох материал	3,022,000.00	480,000.00
35450	Барилгын засварын материал	32,900.00	32,900.00
35470	Бусад хангамжийн материал	13,945,000.00	10,500,000.00
35600	Мал амьтад	1,346,472.00	897,648.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	525,656,668.43	345,065,692.80
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	525,656,668.43	345,065,692.80
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	454,895,668.43	274,304,692.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	174,938,360.00	174,938,360.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(93,062,888.41)	(102,339,868.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	293,297,680.00	250,775,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(160,115,013.44)	(179,351,333.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	460,503,131.02	403,743,886.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(225,055,727.39)	(274,687,983.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,774,346.39	20,985,822.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,215,334.76)	(19,759,689.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,131,400.00	20,131,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,300,284.98)	(20,131,400.00)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	70,761,000.00	70,761,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	70,761,000.00	70,761,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	572,321,334.45	380,573,782.00
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	123,920.00	0
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	123,920.00	0
<b>41300</b>	<b>Өглөг</b>	123,920.00	0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	123,920.00	0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	572,197,414.45	380,573,782.00
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	572,197,414.45	380,573,782.00
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	317,029,861.59	317,029,861.59
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	228,708,089.07	37,084,456.62
51210	Өмнөх үеийн үр дүн	399,382,352.01	228,708,089.07
51220	Тайлант үеийн үр дүн	(170,674,262.94)	(191,623,632.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,459,463.79	26,459,463.79
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	572,321,334.45	380,573,782.00

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	524,634,860.00	440,176,900.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	46,750,460.00	20,725,800.00
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	46,750,460.00	20,725,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,273,400.00	703,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,273,400.00	703,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,404,700.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	20,072,360.00	20,022,000.00

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудиторын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,884,400.00	419,451,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	466,883,000.00	403,675,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466,883,000.00	403,675,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,001,400.00	15,775,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,391,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,001,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,384,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	695,309,122.94	631,800,532.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	695,309,122.94	631,800,532.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557,005,195.11	553,003,787.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,192,614.67	225,920,569.00
210101	Үндсэн цалин	194,097,137.63	195,153,022.00
210102	Нэмэгдэл	30,899,877.04	20,555,147.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,195,600.00	10,212,399.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,438,307.00	29,498,361.00
210201	Тэтгэврийн даатгал	21,012,951.00	20,507,710.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,580,202.00	2,280,205.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,243,904.00	1,807,364.22
210204	Ажилгүйдлийн даатгал	568,371.00	445,734.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,032,879.00	4,457,345.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,196,243.50	9,104,509.96
210301	Гэрэл, цахилгаан	400,243.50	684,509.96
210302	Түлш, халаалт	8,796,000.00	8,420,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,562,788.19	13,996,852.82
210401	Бичиг хэрэг	247,807.18	185,552.82
210402	Тээвэр, шатахуун	15,271,400.00	13,279,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	603,399.00	357,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	224,100.00	175,000.00
210408	Бараа материал акталсны зардал	3,216,082.01	1.00
2105	Нормативт зардал	150,000.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,370,000.00	144,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,290,000.00	144,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,601,000.00	7,114,800.00
210702	Дотоод албан томилолт	1,601,000.00	7,114,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,059,028.00	85,929,895.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,687,408.00	85,522,995.34
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	95,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,120.00	64,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	247,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,435,213.75	181,144,799.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	448,824.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	122,400.00	105,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,312,813.75	180,590,975.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,303,927.83	78,796,744.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,641,399.00	1.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,641,399.00	1.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,662,528.83	78,796,744.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,662,528.83	78,796,744.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(170,674,262.94)	(191,623,632.45)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(170,674,262.94)	(191,623,632.45)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,029,861.59	26,459,463.79	399,382,352.01	742,871,677.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,029,861.59	26,459,463.79	399,382,352.01	742,871,677.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(170,674,262.94)	(170,674,262.94)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,029,861.59	26,459,463.79	228,708,089.07	572,197,414.45
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	317,029,861.59	26,459,463.79	228,708,089.07	572,197,414.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,029,861.59	26,459,463.79	228,708,089.07	572,197,414.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(191,623,632.45)	(191,623,632.45)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	317,029,861.59	26,459,463.79	37,084,456.62	380,573,782.00

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	485,157,800.00	420,154,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,273,400.00	703,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,273,400.00	703,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,273,400.00	703,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,273,400.00	703,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,884,400.00	419,451,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	466,883,000.00	403,675,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466,883,000.00	403,675,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,001,400.00	15,775,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,391,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,001,400.00	-

**Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,384,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	485,157,800.00	420,154,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	485,157,800.00	420,154,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,853,872.17	341,358,155.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,192,613.67	226,044,489.00
210101	Үндсэн цалин	194,097,136.63	195,276,942.00
210102	Нэмэгдэл	30,899,877.04	20,555,147.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,195,600.00	10,212,399.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,438,308.00	29,498,361.00
210201	Тэтгэврийн даатгал	21,012,952.00	20,507,710.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,580,202.00	2,280,205.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,243,904.00	1,807,364.22
210204	Ажилгүйдлийн даатгал	568,371.00	445,734.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,032,879.00	4,457,345.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,516,243.50	8,000,509.96
210301	Гэрэл, цахилгаан	400,243.50	684,509.96
210302	Түлш, халаалт	8,116,000.00	7,316,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,937,799.00	13,951,500.00
210401	Бичиг хэрэг	106,900.00	97,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,009,400.00	13,279,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	603,399.00	357,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	218,100.00	218,000.00
2105	Нормативт зардал	150,000.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	202,000.00	194,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,000.00	194,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,601,000.00	7,114,800.00
210702	Дотоод албан томилолт	1,601,000.00	7,114,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,693,508.00	56,299,495.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,321,888.00	55,892,595.34
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	95,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,120.00	64,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	247,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,400.00	105,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	122,400.00	105,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,303,927.83	78,796,744.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,641,399.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,641,399.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,662,528.83	78,796,744.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,662,528.83	78,796,744.70
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	406,675,600.00	325,582,655.30	81,092,944.70	80%
УРСГАЛ ЗАРДАЛ	406,675,600.00	325,582,655.30	81,092,944.70	80%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,675,600.00	325,582,655.30	81,092,944.70	80%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,261,100.00	226,044,489.00	67,216,611.00	77%

**Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд**

**хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Үндсэн цалин	219,426,800.00	195,276,942.00	24,149,858.00	89%
Нэмэгдэл	63,543,300.00	20,555,147.20	42,988,152.80	32%
Унаа хоолны хөнгөлөлт	10,291,000.00	10,212,399.80	78,600.20	99%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,590,200.00	29,498,361.00	10,091,839.00	75%
Тэтгэврийн даатгал	27,859,800.00	20,507,710.45	7,352,089.55	74%
Тэтгэмжийн даатгал	2,932,600.00	2,280,205.71	652,394.29	78%
ҮОМШӨ-ний даатгал	2,346,100.00	1,807,364.22	538,735.78	77%
Ажилгүйдлийн даатгал	586,500.00	445,734.90	140,765.10	76%
Эрүүл мэндийн даатгал	5,865,200.00	4,457,345.72	1,407,854.28	76%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,138,200.00	8,000,509.96	137,690.04	98%
Гэрэл, цахилгаан	821,300.00	684,509.96	136,790.04	83%
Түлш, халаалт	7,316,900.00	7,316,000.00	900.00	100%
Хангамж, бараа материалын зардал	11,881,900.00	11,200,000.00	681,900.00	94%
Бичиг хэрэг	97,600.00	97,200.00	400.00	100%
Тээвэр, шатахуун	10,530,200.00	10,527,800.00	2,400.00	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,036,000.00	357,000.00	679,000.00	34%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	218,100.00	218,000.00	100.00	100%
Нормативт зардал	150,500.00	150,000.00	500.00	100%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,500.00	150,000.00	500.00	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	202,000.00	194,000.00	8,000.00	96%
Багаж, техник, хэрэгсэл	202,000.00	194,000.00	8,000.00	96%
Томилолт, зочны зардал	2,484,400.00	2,474,800.00	9,600.00	100%
Дотоод албан томилолт	2,484,400.00	2,474,800.00	9,600.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,861,900.00	47,915,495.34	2,946,404.66	94%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,289,200.00	47,508,595.34	2,780,604.66	94%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	-	118,800.00	0%
Даатгалын үйлчилгээ	95,100.00	95,100.00	-	100%
Тээврийн хэрэгслийн татвар	64,300.00	64,300.00	-	100%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,500.00	-	44,500.00	0%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	247,500.00	2,500.00	99%
Бараа үйлчилгээний бусад зардал	105,400.00	105,000.00	400.00	100%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105,400.00	105,000.00	400.00	100%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>406,675,600.00</b>	<b>404,379,400.00</b>	<b>2,296,200.00</b>	<b>99%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>403,675,600.00</b>	<b>403,675,600.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
Улсын төсвөөс санхүүжих	403,675,600.00	403,675,600.00	-	100%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,000,000.00</b>	<b>703,800.00</b>	<b>2,296,200.00</b>	<b>23%</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	703,800.00	2,296,200.00	23%

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	15,775,500.0
УРСГАЛ ЗАРДАЛ	-	15,775,500.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,775,500.00
Хангамж, бараа материалын зардал	-	2,751,500.00
Тээвэр, шатахуун	-	2,751,500.00
Томилолт, зочны зардал	-	4,640,000.00
Дотоод албан томилолт	-	4,640,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	8,384,000.00

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		8,384,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	15,775,500.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,775,500.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,391,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,384,500.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 10 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа нь “Цөлийн бүсийн эмзэг экосистемийн унаган төрхөөр, нэн ховордсон амьтан ургамлыг амьдрах орчинтой нь хамгаалахын сацуу, түүх, соёлын өвийг хамгаалах, танин мэдэх, зохистой ашиглах, улмаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах” эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 695.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 631.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50 хувиар буюу 180.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Өмнөх оны 8.2 сая төгрөгийн авлага барагдсантай холбоотой авлагын үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 35.5 сая төгрөг болж 3.0 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материал бага холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 50.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, хандиваар 23.4 сая төгрөгийн хүлээн авч үйл ажиллагаандаа 76.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 35.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 941.3 сая төгрөг болж 180.6 сая төгрөгөөр буурсан нь 101.1 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл акталсантай холбоотой.

Өмнөх оны 0.1 сая төгрөгийн өглөг барагдсантай холбоотой өглөг дансны үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 380.6 сая төгрөг болж 191.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 19 хувиар буюу 84.4 сая төгрөгөөр буурсан нь санхүүжилтийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 380.5 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 495.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 88.4 сая төгрөгөөр бууруулж, 406.7 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь бараа материал танагдсантай холбоотой.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 406.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 403.7 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлого 3.0 сая төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 325.6 сая төгрөгийг зарцуулж 78.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 325.6 сая төгрөг буюу 80 хувьтай байгаа нь ажил олгогчоос цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 67.2 сая төгрөгөөр, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 10.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.1 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2.9 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 15.8 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба төсөвт байгууллагын өөрийн орлогоос 9.4 сая төгрөг, хандиваар 6.4 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийн орлогыг хангамж, бараа материал, томилолт, зочны, бусдаар гүйцэтгүүлэх зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 429.2 сая төгрөгийн 32 мэдээллийг ил тод байршуулахаас 49.7 сая төгрөгийн 16 мэдээллийг ил тод байршуулж, 379.5 сая төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 1.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 3.2 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснээс бүрэн хэрэгжсэн.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

Дараа жилийн аудитаар хөрөнгийн тооллогын бүртгэл, тээвэр шатахууны зарцуулалтыг үзэх нь зүйтэй.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 70.8 сая төгрөгийн газрыг орхигдуулан тоолсон нь тооллого комиссын гишүүд, тооцоо бодон хянасан нягтлан бодогчийн хариуцлагагүй байдалтай холбоотой тул дараагийн удаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.9 сая төгрөгийн алдаа залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

##### 4.1 Залруулсан алдаа

Нэр бүхий 8 компаниас 9.9 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

##### 4.2 Төлбөрийн акт

Амралт цалин давхардуулан 0.1 сая төгрөгийг ажилтанд илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тээвэр шатахууны зардлаас 0.1 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

##### 4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 0.3 сая төгрөгийн илүү, 2.3 сая төгрөгийн дутуу зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тендерт шалгараагүй иргэн ААНБ-аас 1.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

##### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны	5	14.6	1	9.9	2	0.3	2	4.4	0	0